

Монгол улс бол ертөнцийн нэг хэсэг. Энэ утгаараа Монголын аюулгүй байдал бол дэлхий нийтийн аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг мөн. Ертөнцөд болж буй олон үйл явдал, тэдгээрийн хандлага түүнд шууд болон шууд бусаар нөлөөлнө. Иймд өнөөгийн Монголын аюулгүй байдлын асуудлыг авч үзэхдээ нийт дэлхий дахины, Ази, Номхон да лайн аюулгүй байдал, түүний чиг хандлагыг тодруулахыг хичээх ёстой.

Өнөөдрийн дэлхий ертөнц юуны өмнө шилжилтийн үед байна. Олон улсын харилцааны хуучин систем нурсан боловч шинэ систем бий болоогүй байна. Шилжилтийн ийм байдал 10—20 жил, магадгүй түүнээс ч олон жил үргэлжилж мэднэ. Энэ үед улс орнууд нэг талаас тайвнаар хамтран ажиллах боловч нөгөө талаас өөр хоорондоо сөргөлдсөөр байх шинжтэй. Энэ үеийн дэлхийн аюулгүй байдалд нааштай болон аюултай ямар өөрчлөлт гарсан буюу гарч байна вэ?

### 1. «Хүйтэн дайн»-ы төгсгөл

ЗХУ-д гарсан дотоодын өөрчлөлттэй холбогдон дэлхийд хагас зуун жил ноёрхсон «хүйтэн дайн» дуусаж, бие биенийгээ дайсагнасан хоёр туйлт ертөнцийн бүтэц задрал. Энэхүү шинэ нөхцөл байдалтай холбогдон дэлхийг хамарсан дайн гарах аюул эрс багассан боловч бүс нутаг, салбар бүс нутаг, хөгжиж байгаа ертөнцөд дайн, мөргөлдөөн гарах нөхцөл боломж нэмэгдэв.

Хэдийгээр бүх дэлхийг хамарсан дайны аюул багассан ч бүс нутгийн шинжтэй их гүрнүүд хүч чадлаа зузаатгаж байгаа нөхцөлд дэлхийн хамгийн хүчирхэг гүрэн-АНУ «хүйтэн дайны» үеийн нөлөөгөө хэвээр хадгалахад онц бэрхшээлтэй боллоо. Урьд нь АНУ-ын холбоотон буюу түүнийг талархаж байсан улсууд үндэсний эрх ашигтаа дулдуйдан олон улсын харилцаандаа чөлөөтэй хөдөлж, хэт их гүрнүүдийн үлдээсэн хоосон зайг бөглөхийг эрмэлзэх бололтой.

Нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд, хэт их гүрнүүдийн нөлөө харилцан адилгүй буурсан явдал юм. ЗХУ бутарсан нь түүний толгойлсон Варшавын гэрээг нурахад хүргэж, энэ хэт их гүрний дэлхийн бодло год эзлэх байр суурь, жин нөлөө Америкийнхтай харьцуулахад эрс унав. Тэр ч бүү хэл Орос улсын ГЯЯ-ны олон улсын харилцааны төвийн багш, эрдэмтдийн бичсэнээр өнөөдрийн Орос орон хэт их гүрэн, тэр ч байтугай их гүрэн бус, олон улсын бодлогын зах хязгаарын хоцрогдсон мужийн (провинциальная периферия мировой политики) шинжтэй болжээ.

Гэхдээ Оросын (Зөвлөлтийн улс төр, эдийн засгийн нөлөө унасан боловч цэргийн хүч чадал нь бараг хэвээрээ байна.

«Хүйтэн дайны» үеийн хоёр туйлт системийн үед аюул гэдэг ойлголт, түүний эх сурвалж тодорхой байсан. Гэтэл ЗХУ задарсантай холбогдож Өрнөдийн орнуудын аюулгүй байдалд заналхийлж байсан тодорхой аюул алга болжээ. Энэхүү тодорхой аюул Өрнөдийн орнууд Зөвлөлтийн аюулын эсрэг эв нэгдлээ бэхжүүлэх гол хүчин зүйл болж байлаа. Нэгэнт тодорхой дайсан гэж байхгүй болсон болохоор батлан хамгаалахын төсөв, зардлыг яаж тооцож, ямар хэмжээгээр тогтоох нь бас л тодорхойгүй болсон байна.

\* Г. Төмөрчулуун — Түүхийн ухааны дэд эрдэмтэн

## **2. Эдийн засгийн хүч чадал аюулгүй байдлын гол элемент болсон нь**

Хэт их гүрнүүдийн уналт бууралтад нөлөөлсөн чухал хүчин зүйл бол тэдгээрийн эдийн засгийн хүчин чадал буурсанд оршино. Тэгвэл эдийн засгийн хүч чадлыг юугаар хэмжих ёстой вэ? Миний бодоход эдийн засгийн хүч чадал гэдэг нь бусад улсын бодол санаа, үйл ажиллагааг өөрийн хүссэн чиглэлд өөрчилж чадах чадвар гэж томъёолж болох мэт. Эдийн засгийн хүч чадал хоёр чиглэлд үйлчилж болно: улс орнуудын харилцан уялдаатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, эдийн засгийн чанартай мөргөлдөөн.

Эхний чиглэлийн тодорхой жишээнд ЕЭЗХ юм уу энэ оны эхээр АСЕАН-ы орнуудын тунхагласан худалдааны чөлөөт бүс байгуулах тухай шийдвэрийг тусгаж болох юм. Хоёр дахь чиглэлийн тодорхой жишээ нь Америк-Японы эдийн засгийн харилцааны байдал юм. АНУ хүйтэн дайны үеийн дайснуудтайгаа дахин сөргөлдөхөөсөө хуучин анд, холбоотнуудтайгаа эдийн засгаас болж халз тулж мэднэ гэж зарим эрдэмтэд, улс төрийн зүтгэлтнүүд үздэг явдал элбэг. Үнэхээр ч худалдаа, протекционизм, гадаад өр төлбөр, өлсгөлөн ядуурал нь санал зөрөлдөөн, сөргөлдөөнд хүргэхгүй гэсэн баталгаа алга. Эдгээр асуудал хамтын аюулгүй байдлын шинэ хэлбэр, бүтцийг буй болгож мэдэхээр байна.

Улс орнуудын эдийн засгийн харилцан хамаарал бүх нийтийн амгалан байдалд хүргэнэ гэж либерал эдийн засагчид үздэг (Жишээ нь, Адам Смит). Гэтэл зарим нь үүнд эргэлзэж, эдийн засгийн арга хэрэгслээр бусдыг хараат болгох, хяналт тогтооход орчин үеийн олон улсын эдийн засгийн харилцаа чиглэж буй бөгөөд энэ нь нэг ёсондоо урьдын гео-политика (газарзүйн байрлалд тулгуурласан улс төрийн гадаад бодлого) өнөөгийн гео-экономикийн (газарзүйн байрлалд тулгуурласан эдийн засгийн гадаад бодлого) зарчимд шилжиж буйг (реалист" сургуулийнхан) харуулж байна гэж тэд үздэг.

## **3. Дэлхийн эдийн засгийн гол гол төвийн байрлал өөрчлөгдөж байгаа нь**

Одоогоос хоёр жилийн өмнө Дэлхийн эдийн засгийн хөгжлийн гол төв Атлантын далайгаас Номхон далайд шилжсэн тухай анх ярьж бичиж эхэлсэн. 1980-аад оны сүүлээр Г. Қиссенжер, З. Бзежинский зэрэг 10 гаруй томоохон улс төрийн зүтгэлтэн, эрдэмтдийн боловсруулсан «АНУ-ын удаан хугацааны нэгдсэн стратеги» судалгаанд тэмдэглэхдээ 2010 онд Япон, Хятад, Өмнөд Солонгос, Тайваны үндэсний бүтээгдэхүүний нийлбэр АНУ-ынхаас давж гарна гэж тооцоолж байв.

Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл (ПЕКК)-ийн тооцоогоор Ази, Номхон далай дэлхийн хамгийн түргэн хөгжигч бүс нутаг хэвээр байна. 1991 онд энэ бүс нутгийн эдийн засгийн өсөлт 2,7 хувь байсан бол энэ онд 3,5 хувь, 1993 онд 4,7 хувиар өсөх ажээ. 1992, 1993 онд бүс нутгийн тэргүүлэгч хоёр гүрэн— АНУ, Японы эдийн засаг Нэлээд өсөхөөр байна.

Бүс нутгийн шинээр үйлдвэржсэн орнууд-Өмнөд Солонгос, Тайван, Гонконг, Сингапурын эдийн засгийн өсөлт наяд оныхтой харьцуулахад буурах боловч Индонез, Номхон далайд гарцтай Латин Америкийн орнууд илүү түргэн хөгжиж эхлэв.

Гэвч Европ тив Ази, Номхон далайтай эдийн засгийн өсөлтөөр өрсөлдөгч гол тив хэвээр байх бололтой. Өнгөрсөн оны сүүлээр Маастрихт хотноо ЕЭЗХН-ийн гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын гарын үсэг зурсан, хэрэг дээрээ Европын нэгдсэн улсыг байгуулах тухай

Тунхаглал ийм дүгнэлтэд хүргэж байна. ЕЭЗХН-ийн 12 улс дээр Европын чөлөөт худалдааны бүс (ЕФТА)-ийн Австри, Финланд, Исланд, Швед, Швейцар, Норвеги, цаашилбал социалист гэгдэж байсан Төв, Зүүн Европын орнууд, мөн ТТУХН-ийн орнууд нэгдвэл Европ тивд хүчирхэг эдийн засаг гарч ирэх нь тодорхой. Аж үйлдвэр өндөр хөгжсөн 7 гүрний 4 нь Европт байдаг. Европ, АНУ, Японы орчин үеийн хүчирхэг технологи Дорнод Европыг богино хугацаанд хөл дээр нь босгох бүрэн бололцоотой. Дорнод Европт эдийн засгийн дэд бүтэц харьцангуй өндөр хөгжсөн, газарзүйн хувьд ойр дөт, Азийг бодвол цаг агаар, зан заншил, шашин, соёл иргэншил ойролцоо зэрэг нааштай олон хүчин зүйл бий юм.

#### **4. Цэргийн хүчин зүйлийн ач холбогдол буурч байгаа нь**

1990-ээд онд олон улсын аюулгүй байдлын салбарт гарсан, магадгүй, хамгийн том өөрчлөлт бол улс орнуудын хоорондын харилцаанд, тодорхой их гүрний хүч чадлын тухай онол, практикт цэрэг, зэвсгийн үүрэг, ач холбогдол 1648 онд Вестфалийн энх тайвны Гэрээнд үсэг зурснаас хойших 350 гаруй жилийн хугацаанд анх удаа эрс буурсан явдал юм. Цэргийн хүч чадлын оронд шинийг сэтгэх, бүтээх оюуны их хүч чадлыг дагасан эдийн засгийн хүч чадал шийдвэрлэх үүрэгтэй болов. Цэргийн хүч чадлын ач холбогдол ийнхүү буурсан нь нөгөөтэй гүүр тодорхой улс орнуудын дотоодод, олон улсын улс төрийн харилцаанд гарч буй өөрчлөлт, зэвсгийн тархалт, худалдаа, технологийн шинэчлэл (цэргийн) хүн төрөлхтөнд асар их гай гамшиг учруулах боломжтойг улс орнууд ухаарч эхэлсэнтэй холбоотой байлаа. Ийм нөхцөлд зэвсгийн хүчээр асуудлыг шийдэх нь ёс суртахуун, улс төр, эдийн засгийн хувьд дааж давшгүй их өртөг үнэтэй болжээ.

Хэт их гүрнүүдийн нөлөө буурч, эдийн засгийн хүчин зүйлийн ач холбогдол нэмэгдэж, цэргийн аюул заналын тухай сонгодог ойлголт бүдгэрсэн зэрэг нь цэргийн эвслүүдийг тогтворгүй болгох үндэс болов. Цэргийн эвсэл холбоо шинээр байгуулах, хуучнаа хэвээр үлдээх нь улам бүр үнэтэй, улам бүр хэцүү болж байна. Иймд Америкийн цэргийн мэргэжилтнүүдийн бичиж байгаагаас үзэхэд, цэргийн эвслүүд цаашид байнгын бус, харин тодорхой асуудлаар, түр зуурын (ад хок) шинжтэй байх бололтой.

#### **5. «Хоёр туйлын» түүхэн үе дуусаж, бүс нутгийн их гүрнүүд гарч ирсэн нь**

Дээр тэмдэглэсэнчлэн, дэлхийн хоёрдугаар дайны дараа бүрэлдэн тогтсон хоёр туйлт ертөнц бутарсантай холбогдон «хүйтэн дайн», «Тогтоон барих стратеги», НАТО, Варшавын гэрээ зэрэг ойлголт чөдөр тутмын хэллэгээс алга болов. Түүний оронд олон туйлт дэлхий үүсэж эхэлж байна. Америкийн эрдэмтэд, одоогоор 6 туйлт дэлхийн тухай ярьж байна. Үүнд: АНУ, Нэгдсэн Герман, Япон, Хятад, Орос, Энэтхэг. Ийм дэлхий ертөнц хоёр туйлт ертөнцийг бодвол илүү тогтворгүй байх бололтой. Дээрх туйлуудын нэг хэсэг нь цэргийн хүчин чадлын хувьд их гүрний статустай байхад нөгөө хэсэг нь эдийн засгийн хүчин чадлаараа их гүрний тоонд орж буй.

Шинээр бүрэлдэн буй дэлхийн аюулгүй байдлыг тогтворгүй болгож буй нэг чухал хүчин зүйл бол бүс нутгийн их гүрнүүд гарч ирсэн явдал юм. Ийм гүрнүүдийн тоонд Энэтхэг, Хятад, Япон, Герман, Ирак, Иран, Бразил, магадгүй Нэгдсэн Солонгос улс орж байна.

Хамгийн аюултай нь эдгээр улсын аль алиныг «сэтгэл нь ханасан» гүрэн гэж хэлэхэд хэцүү юм (Энэтхэг Зүүн өмнөд Азидаа ноёрхох, Хя-

тад болж өгвөл хөгжиж буй бүх улсыг араасаа дагуулах, Герман Европт гол гүрэн болох г. м, улс бүр өөр өөрийн зорилго, сонирхолтой). Иймд дээрх олон туйлт хэврэг ертөнц сонгодог их гүрнүүд, шинэ их гүрнүүдийн хоорондын зөрчил, маргаанд өртөхгүй гэх үндэсгүй.

## **6. Олон улсын байгууллагуудын шинэ үүрэг роль**

Цэргийн эвслүүд бутарч, эдийн засгийн ач холбогдол өсөх тусам олон улсын байгууллагуудын үүрэг цаашид нэмэгдэх хандлага гарч ирэв. НҮБ-ын оролцоотойгоор Иракийг Кувейтээс хөөн гаргасан хийгээд Аюулгүйн Зөвлөлөөс Сербийн удирдлагын эсрэг авсан эдийн засгийн хориг арга хэмжээ энэ хандлагын тодорхой жишээ юм. Цаашил бал, өнөөдөр Қамбож, Афганистан, Ойрх Дорнод, тэр ч бүү хэл, Қарабахын асуудлыг шийдэхэд НҮБ, олон улсын бусад байгууллага чухал үүрэг гүйцэтгэх боллоо.

Европын хамтын нийгэмлэг, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын оролцоогүйгээр Европ тивийн ямар ч чухал асуудлыг шийдвэрлэх бололцоогүй болов.

АПЕК, ПЕКК зэрэг бүс нутгийн интеграцын байгууллагуудын ач холбогдол өссөөр байна. Түүнчлэн эдийн засгаа хөгжүүлэхийг эрмэл зэгч улс орнууд ГАТТ, ОУВС, ДБ, АХБ, ЕЭЗХН зэрэг олон улсын санхүү-эдийн засгийн байгууллагуудын тусламжид улам их дулдуйдах болов. Энэ бүхэн нь тусгаар улсуудын уламжлалт бүрэн эрхт байдлын тодорхой хэсэг олон улсын байгууллагуудад шилжиж байгааг харуулж байна.

## **7. Соёл иргэншлийн зөрчил хурцдах нь**

Хэдийгээр улс орнууд эдийн засаг, технологийн хөгжлийн шаардлагаар ойртон, уялдаа холбоогоо бэхжүүлэх боловч улс орнуудын соёл, шашин, зан заншил, үндсэрхэх үзэл, үндэстнүүдийн хоорондын зөрчил (тодорхой улс орнуудын хоорондын болон тодорхой улс доторх зөрчил) улам гүнзгийрэх хандлага зонхилж байна. Энэ хандлага олон үндэстний улс орнуудыг дотроос нь хагалахад ч хүргэж болох юм. Ийм хандлага хүчтэй илрэх улсуудын тоонд Орос, Энэтхэг, Хятад, Канад юуны өмнө орж байна. Түүхийн үүднээс авч үзвэл эзэнт улс задрах үйл явц хэзээд сөргөлдөөн мөргөлдөөн, гүнзгий зөрчилтэй байдалд хэрэгждэг. Иймд шашин, соёл иргэншил, үндэстэн ястны зөрчил нь олон улсын аюулгүй байдалд заналхийлэх ноцтой хүчин зүйл болж байна.

## **АЗИ, НОМХОН ДАЛАЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАНДЛАГА**

### **1. Бүс нутгийн их гүрнүүдийн шинэ бүтэц**

Хэт их гүрнүүдийн нөлөө буурч, олон туйлт ертөнц бий болж буй өнөө үед Ази, Номхон далайн бүс нутагт хоёр зэрэглэлтэй их гүрнүүдийн тогтолцоо үүсээд байна. Эхний төвшинд багтах гүрнүүд 2000 он гэхэд бүс нутгийн үйл явдлын өрнөлтөд шийдвэрлэх нөлөө үзүүлж, Тэнд хэт их гүрнүүдийн үлдээсэн хоосон орон зайг эзлэх бололтой. Ийм гүрний тоонд Япон, Хятад, Энэтхэг орж байна. Хоёр дахь төв шинд бүс нутгийн байдалд нөлөөлөх санаа байвч чадал тэнхээ нь хүрэхгүй улсууд, тухайлбал, Өмнөд Солонгос (харин Нэгдсэн Солонгос улс I ангилалд орно), Индонез, Тайван, Вьетнам орох юм.

## **2. Эдийн засгийн өрсөлдөөн**

Дээр тэмдэглэсэн гео-экономикийн бодлого Азид хүчтэй явагдана гэж гадаадын эрдэмтэд бичиж байна.

Японы Шинтаро Ишихара «XXI зуун бол эдийн засгийн дайны зуун болно» гэжээ. Америкийн эрдэмтэн Бернард Гордон бичихдээ: «Хэдийгээр бүс нутгийн улс орнуудын удирдагчид чөлөөт худалдааны үзэл санааны төлөө байгаа боловч практик бодлого нь түүнтэй эрс зөрчилдөж байна» гэжээ. «Ази, Номхон далайн хувьд гэвэл гео-экономикийн ийм мөргөлдөөн Америк, Японы хооронд амархан гарна» гэж Фред Бэргсштэн бичсэн байна. Энэ бүхэн эдийн засгийн зөрчилд үндэслэсэн сөргөлдөөн Ази, Номхон далайд элбэг гарах төлөвтэйг харуулж буй биз ээ.

## **3. Хил хязгаарын асуудал**

Бүс нутгийн аюулгүй байдалд ноцтой нөлөөлөх хүчин зүйл бол хил хязгаарын асуудал юм. Ази, Номхон далайд дэлхийн хуурай замын 10 томоохон гүрний 7 нь байрладаг. Газар нутгийн маргаан бүс нутгийг тогтворгүйжүүлэх хүчин зүйл хэвээр байна. БНХАУ нийт 13 улстай 7000 миль газраар хиллэдэг. Бараг улс бүртэй хилийн маргаантай.

БНХАУ хилийн асуудлаар хуучин ЗХУ, Энэтхэг, Вьетнамтай дайн хийж байв. Энэтхэг, Пакистан, Орос, Япон, Камбож, Тайланд, Папуа Шинэ Гвиней, Индонез, Хойд, Өмнөд Солонгос бүгд газар нутгийн хурц асуудалтай. Маргаантай нутгийн орчим их хэмжээний цэрэг зэвсгийн хүч бөөгнөрч байна.

## **4. Бүс нутгийн түгшүүртэй байдал**

Бүс нутгийн одоогийн байдлыг авч үзвэл байдал намжих чиглэлд байна гэж дүгнэж болох юм. Энэ нь хүйтэн дайн дууссан, ЗХУ бутар сан, бүс нутгийн хэрэг явдалд үзэл суртлын үүрэг нөлөө буурсантай холбоотой юм. Бүс нутаг дахь Америк, Зөвлөлтийн өрсөлдөөнд хамаарахгүй халуун цэгүүд ч унтрах хандлагатай. Японы ерөнхий сайд байсан Қайфу Хятадад ирж, ХКН-ын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Зян Зимен Японд айлчлав. Хятад-Энэтхэгийн харилцаа сайжирч, хилийн маргаанаа зохицуулахаар ажиллаж, дипломат харилцаа тасраад 25 жил өнгөрсний дараа 1990 оны 8 дугаар сард Хятад-Индонезийн харилцаа хэвийн болов. Хятад, Өмнөд Солонгос хоёр дипломат харилцаа тогтоох нь өнөө маргаашийн асуудал болов. Хятад, Вьетнам хоёр ч харилцаагаа илт сайжрууллаа. Харин Спратли арлын асуудал хоёр орны хооронд шийдэгдээгүй хурц асуудал юм.

Гэвч харамсалтай нь байдал ийнхүү хэвийн болж байгаа нь түр зуурын шинжтэй болов уу.

## **5. Шинэ түгшүүр, шинэ шинэ голомт**

— Зарим улс өөрийн хэмжээ, цэрэг, эдийн засгийн хүч тэнхээнд тохирсон байр суурьтай болохыг илт эрмэлзэх боллоо. Намжмал байдлыг хэвийн болгоход нэг талаас улс төрийн болон эдийн засгийн хувьд хүчирхэгжих гэсэн оролдлого, нөгөө талаас эндхийн улс орнуудын хоорондох хэзээний бие биендээ үл итгэлцсэн, дайсагнасан байдал саад болох төлөвтэй. Гэвч хамгийн их аюул бүс нутгийн эрээн цоохор соёлын бүтцэд оршино. Энд эдийн засгийн интеграцыг хөгжүүлэхэд дээрх соёлын ялгаа ихээхэн бэрхшээл учруулж байна. Өөр соёл, өөр шашинтай хүмүүсийг нэг гэрт байлгах нь туйлын төвөгтэй хэрэг. Япончууд болон солонгосчууд, япончууд болон хятадууд, вьетнамчууд болон хятадууд бие биенийгээ хэзээнээс үздэггүй билээ. Өөр өөр соёл-

той улсууд гэвэл Орос, Хятад, Орос, Япон гэх мэт олон жишээ авч болох юм.

— Олон намын систем тогтоох, ардчилах үйл явц Европ, Латин Америк, Африкт эрчимтэй өрнөж байхад Азийн орнууд (Хятад, Лаос, Вьетнам) урьдын нэг намын системээ хадгалж, харин эдийн засгийн нээлттэй бодлого явуулах чиглэл баримталж байна. Гэвч алс хэтдээ хаалттай улс төрийн систем, нээлттэй эдийн засаг хоёр зөрчилдөхгүй гэх газаргүй. Ийм зөрчлийн анхны хэлбэрүүд сүүлийн үед гарч эхлэв (Жишээ нь, Хятадын эрэг хавийн нээлттэй бүсүүд, Хятадын төв удирдлагын хоорондын зөрчил, хүний эрх, үндэстэн хоорондын харилцааны асуудал г. м).

— Хоёр Солонгосыг нэгтгэх асуудал бол хүйтэн дайны сүүлчийн үр дагаврыг устгах тухай асуудал юм. Гэвч аливаа юм сайн муу хоёр талтай. Солонгосын хувьд нэгтгэх нэг хэцүү, нэгдэхгүй байх бас хэцүү. Нэгдэнэ гэхээр Япон, Хятад зэрэг томоохон гүрнүүд өөртэй нь өрсөлдөх тэнхээтэй Нэгдсэн Солонгос гарч, ЗХА дахь хүчний тэнцвэрийг алдагдуулж болзошгүй гэж болгоомжилно. Нэгдэхгүй гэхээр хоёр Солонгосын зөрчил цөмийн дайнд ч хүргэж болзошгүй аюул байна.

—Хятад, Хойд Солонгос, Индонез, Бирм, Вьетнам зэрэг орны өндөр настай удирдлагууд солигдоно. Эдгээр халаа сэлгээтэй холбогдон төрийн эрх булаацалдах тэмцэл явагдаж, эдгээр улсын дотоодод байдал тогтворгүйтэн, гадаад бодлого нь түрэмгий шинж чанартай болж, бүс нутгийн байдалд заналхийлж болзошгүй.

— Ази, Номхон далайн орнууд дэлхийн худалдаанаас ихээхэн хараат тул дэлхийн эдийн засаг хямралд орох нь энэ бүс нутагт урьдчилан тааварлахад хэцүү үр дагаварт хүргэнэ. Худалдаанд элдвээр саад хийх, протекционист бодлого явуулах, амин хувиа хичээх зэрэг худалдааны нааштай бус бодлого бүсийн аюулгүй байдалд ч мөн нөлөөлөх юм.

— АНУ бүс нутгаас цэргээ бүрэн гаргаж, цэрэг улс төрийн оролцоогоо энд зогсоовол түүний үлдээсэн хоосон зайг дүүргэх тэмцэл бүсийн их гүрнүүдийн хооронд өрнөж, дайны ноцтой аюул нүүрлэнэ. Энэтхэг, Хятад, Япон гурав дээрх зайг өөрсдөө эзлэхийг юуны өмнө хичээх болно. Уг зайг Япон эзэлнэ гэвэл Азийн орнуудад дэлхийн хоёрдугаар дайны үеийн Японыг санагдуулах тул үр дагавар нь таахад хэцүү болно. Хятад эзэлнэ гэвэл тийнхүү эзлэхийг Япон, Тайван, Энэтхэг, Орос юу гэж үзэхийг хэлэхэд бэрх, Энэтхэг эзэлдэг юм гэхэд ялангуяа Хятад, АСЕАН-ы орнууд ямар хариу алхам хийх нь тодорхой бус. Иймд АНУ энд их гүрнүүдийн хүч, сонирхлыг тэнцвэржүүлэгчийн үүрэг гүйцэт гэж байгаа бөгөөд энэ тэнцүүлэгч алга болбол Азийн байдал хямарч, Дэлхий нийтийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

### **Төв Ази**

ЗХУ бутарсантай холбогдон Төв Азид шинэ байдал бий болов. Тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөл үүсэж, түүний бүрэлдэхүүнд ордог улсууд өөр хоорондоо (тухайлбал, Казахстан, Узбекистан, Кыргызстан) Орос улстай хоёр талын болон олон талын аюулгүй байдлын гэрээ байгуулж эхлэв.

Төв Азийн улсуудыг Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хуралд гишүүнээр элсүүллээ. Эдгээр шинэ улсад нөлөөгөө тэлэх тэмцэлд уламжлалт их гүрнүүдийн зэрэгцээ Иран, Турк, Пакистан идэвхтэй оролцож эхлэв. Салбар бүс нутагт нөлөөгөө тэлэх энэхүү уралдаанд Туркийг АНУ, Өрнөдийн бусад орон, Ираныг лалын фундаменталист шашинтай улсууд дэмжиж байна. Төв Азид шинээр үүссэн улсуудын хөгжлийн хэтийн хандлагыг таахад одоогоор хэцүү гэдэг нь

ойлгомжтой. Байдлыг ажиглахад Афганистан, Узбекистан, Туркменистан лалын фундаменталист орнуудын жишгээр, бусад улс Туркийн жишгээр хөгжих бололтой.

Төв Азийн улсууд газарзүйн байрлал, цаг агаар, эдийн засгийн хөгжлийн онцлог зэргээс үүдэн нийгэм, эдийн засгаа хөгжүүлэхэд ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна. Далайд гарцгүй, хүн ам нь тархай бутархай суурьшдаг, эдийн засгийн дэд бүтэц, аж үйлдвэр сул хөгжсөн, эрс тэс уур амьсгалтай зэрэг нийтлэг асуудал олон байна. Үүний зэрэгцээ нутаг дэвсгэр, хил хязгаар, үндэстэн ястан, шашин, соёлын өвөрмөц онцлогтой холбогдон Төв Азид түгшүүрийн шинэ ши нэ голомт үүсэхгүй гэх газаргүй юм. Нэн ялангуяа лалын шашны фундаменталист хэлбэр Төв Азид дэлгэрвэл энд өөр өөр соёл иргэншлийн хурц мөргөлдөөнд хүргэж болзошгүй.

## МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Олон улсын аюулгүй байдлын дээрх хандлагууд Монголын үндэсний аюулгүй байдалд таван чиглэлээр нөлөөлөх бололтой. Үүнд:

- Ардчилыг бэхжүүлэх, хүний эрхийг бататгах дэлхий дахины хандлага;
- Дэлхий ертөнц хоёр туйлаас олон туйл руу шилжих шилжилтийн үедээ орсон, уламжлалт их гүрнүүдтэй эн зэрэгцэн бүс нутгийн их гүрнүүд гарч ирсэн;
- Олон улсын эрх, түүнд тулгуурласан олон улсын байгууллагууд улс орнуудын аюулгүй байдалд улам бүр чухал үүрэг гүйцэтгэх болсон;
- Олон улсын болон улс орнуудын аюулгүй байдлын бодлогод цэргийн хүчин зүйлийн үүрэг буурч, эдийн засгийн хүчин зүйлийн ач холбогдол эрс нэмэгдсэн;
- Соёл иргэншил, үндэстнүүдийн хоорондын зөрчил хурцдаж, 100- 200 жилийн өмнө Европт хүчтэй дэлгэрсэн үндэсний үзэл Азид эрч хүчээ авч эхэлсэн зэрэг болно.

Монгол улсын ирээдүйг ардчилалгүйгээр төсөөлөх аргагүй. Манай шинэ Үндсэн хуульд ч энэ агуулгаар орсон. Гэвч ардчилал гэдэг маань анархи байдал биш. Энд хуульд үндэслэсэн хуулийг дээдэлсэн ардчиллын тухай ярьж байна. Ардчилсан Монгол улсыг ардчилсан олон улсын хамтын нийгэмлэг дэмжинэ. Ардчилалгүй Монгол олон улсын тавцанд ганцаардана. Ганцаардах нь тусгаар тогтнолоо алдахтай утга дүйнэ. Ардчилал гэдэг нь дан ганц Америкийн ололт биш ээ. Ардчилал бол хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл. Иймд ардчиллыг дотроо бэхжүүлж, гаднаа дэмжих нь Монголын гадаад бодлогын нэг чухал зорилго мөн. Иймд ардчилсан буюу ардчилал руу тэмүүлж буй орнуудтай, ардчиллын үнэт зүйлсийг хуваалцдаг улсуудтай илүү дотно харилцахад чиглэсэн дипломат үйл ажиллагаа явуулах нь Монголын үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх нэг үндэс юм.

Хүн төрөлхтний үнэт зүйлийн хувьд ардчилах үйл явц дэлхийн хөгжлийн ерөнхий хандлага мөн боловч ардчилал бүх дэлхийд ялсан гэвэл үнэнд нийцэхгүй. Өнөөгийн олон улсын систем олон туйл руу шилжиж, уламжлалт их гүрнүүдтэй зэрэгцэн бүс нутгийн их гүрнүүд гарч ирж байгааг Монголын дипломат бодлого анхаарах ёстой. Шинэ их гүрнүүд бүгд ардчилсан дэглэмтэй гэж үзэх үндэсгүй. Их гүрний статус өөртөө олон элемент агуулдаг. Тэдгээрийг дотор нь улс төрийн, цэргийн, эдийн засаг-санхүүгийн, худалдааны их гүрэн гэх мэтээр ангилж болно. Өнөөдөр эдгээр элементийг бүхлээр нь юм уу аль нэгийг

нь агуулсан 6 их гүрэн (АНУ, Нэгдсэн Герман, Япон, Орос, Хятад, Энэтхэг) байна. Эдгээр улс Монголын талаар түүхийн тодорхой үед өөр өөрийн онцлогтой бодлого явуулж ирсэн. Монгол улс олон улсын харилцааны ерөнхий чиг хандлага, өөрийн газарзүйн байрлал, хөгжлийн хэрэгцээ шаардлага, үндэсний эрх ашгаа няхуур бодолцон дээрх улсуудтай харилцах нь чухал. Чингэхдээ гагцхүү өөрийн эрх ашгийг урьтал болгох бус, тухайн улсын сонирхол хэрэгцээг мөн бодолцох ёстой. Аливаа дипломат үйл ажиллагаа бол юуны өмнө хэлцэл, тохиролцоо байдаг. Тэгэхдээ ямар ч тохиролцоо байсан олон улсын хуульд үндэслэх ёстой.

Өнөөгийн олон улсын харилцааны бас нэг чухал онцлог нь, дээр тэмдэглэсэнчлэн, олон улсын эрх, түүнд суурилсан олон улсын байгууллагуудын үүрэг роль илт нэмэгдсэн явдал юм. Олон улсын эрхийн субъектүүд болон улс орнууд олон улсын эрх, тухайлбал, НҮБ-ын Дүрмийн өмнө адил эрх эдэлж, адилхан үүрэг хүлээх ёстой. Дүрмээр хүлээсэн үүргээ зөрчсөн улс олон улсын эрхийн дагуу хариуцлага хүлээдэг (Ирак, Югослав). Иймд олон улсын эрхийг дээдэлж, олон улсын байгууллагуудын үүргийг дээшлүүлэх, тэгснээрээ аюулгүй байдлын олон улсын эрхзүйн баталгаагаа бэхжүүлэхийн төлөө тэмцэх нь Монгол шиг бага буурай орны хувьд зарчмын ач холбогдолтой.

Гэхдээ хууль бүр шударга байгаагүйг мөн бодолцох ёстой. Жишээ нь, НҮБ-ын бүх гишүүд дүрмийн өмнө тэгш эрхтэй гэсэн атлаа Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүн яагаад бусдаас илүү эрх эдэлдэг билээ? Монголын хоёр хөрш хоёулаа Аюулгүйн Зөвлөлийн гишүүн. Монголын аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой аливаа асуудлаар Аюулгүйн Зөвлөл шийдвэр гаргахад хүрвэл хөрш хоёр улсын аль нэг нь дүрмийн дагуу хориг тавих эрхээ эдлэх тийм тохиолдол онолын хувьд ч, практикийн хувьд ч байж болно.

Олон улсын харилцаанд хууль чухал боловч үндэсний аюулгүй байдлыг дан ганц хуульд даатгах нь бас л учир дутагдалтай. Харамсалтай нь, олон улсын харилцааг хуулиар зохицуулах тухай Уго Гроцийн мөрөөдөл, дэлхий нийтийн «мөнхийн энхийн гэрээ»-ний тухай Қантын хосгүй сургаал амьдралд хэрэгжтэл бас ч чамгүй их хугацаа шаардагдах бололтой.

Өнөөгийн Монголын аюулгүй байдлын, магадгүй, хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг бол эдийн засгийн хүчин зүйл юм.

Олон улсын харилцааны өнөөгийн хандлагаас үзвэл хэн хүчтэй эдийн засагтай, хэн оюуны их багтаамжтай, хамгийн тэргүүний техник, технологийг хамгийн бага хугацаанд үйлдвэрлэлд нэвтрүүлж байна, тэр улс оршиж буй бүс нутгийнхаа төдийгүй, дэлхий нийтийн хөгжлийг тодорхойлон, залж байна. Хэн дээд зэргийн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын худалдааны эргэлтэд оруулж чадна, тэр дэлхийд ноёрхох болж байна. Хүчтэй эдийн засагтай улсын аюулгүй байдал тэр хэмжээгээр баталгаажсан байдаг. Иймд эдийн засгийн хүч чадал бол улсын нийт чадавхийн, түүний аюулгүй байдлын гол хүчин зүйл болж өгдөг.

Буурай хөгжилтэй орон баян улсуудын гарыг харж, тэдний ивээл дор хөгждөг. Энэ утгаараа тэдний аюулгүй байдал нь хэврэг, их төлөв бусдын хараат байдаг.

Өнөөгийн Монголын үндэсний аюулгүй байдлын гол асуудал чухамдаа эдийн засгийн шинжтэй байгаа юм. Эдийн засгийн хуучин тогтолцоо халагдсан боловч шинэ тогтолцоо бий болж чадаагүй байна. Эдийн засгийн уналтыг зогсоох, улмаар эдийн засгаа тогтворжуулах, цаашид хөгжих суурийг тавих нь манай өнөөгийн дотоод дахь нэн чухал зорилт болж байна.

Эдийн засгийн аюулгүй байдлын гадаад талтай холбогдох нэг асуудлыг энд хөндөхийг хүснэ. Олон улсын эдийн засгийн харилцааны өнөөгийн нэг гол онол болох либерал онолчдын үздэгээр (Адам Смит) эдийн засгийн харилцаа Засгийн газрын бодлогоос үл хамааран «үл үзэгдэх гар»-аар буюу зах зээлээр, өөрөөр хэлбэл, хэрэгцээгээр зохицуулагдаж байдаг. Либерал Эдийн засагчдын хувьд улс орнуудын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, хил хязгаар гэдэг ойлголт байдаггүй, гагцхүү дэлхий нийтийн нэгдсэн нэг л аж ахуй буй. Энэ талаар бол улс орнууд төрийн тусгаар тогтнолоо умартан, хил хязгаараа чөлөөтэй нээж, хөрөнгө, ажиллах хүч, үйлчилгээг ямар ч хавчилт, хяналтгүйгээр (протекционизм) чөлөөтэй солилцож, нэвтрүүлэх ёстой. Энэ хандлагын тодорхой жишээ нь ЕЭЗХН юм.

Меркантилистүүд болохоор зах зээлийн эдийн засгийн хуулийг дагадаг боловч аюулгүй байдал, бүрэн эрхт байдал, төрийн тусгаар тогтнолыг дээдлэн үзэж, олон улсын эдийн засгийн харилцаа, чөлөөт худалдаа улс орны аюулгүй байдалд хохирол учруулахгүй байх хэмжээнд явагдах ёстой гэж үздэг. Иймээс ч тэд улс орнуудын үндэсний эрх ашиг бол үүрд тахин шүтвэл зохих цорын ганц шүтээн гэж үзэж, олон улсын эдийн засгийн аливаа үйл ажиллагаанд оролцохдоо гагцхүү түүнийг удирдлага болгодог. Тэд гадаадын бараанаас өндөр татвар авах зэргээр өөрийн эдийн засгийг гаднын нөлөөнөөс аль болох хамгаалахыг эрмэлзэж, Засгийн газрын оролцоог хүчтэй болгохыг шаарддаг.

Манай хувьд өнөөдрийн байдлаар эхний онол давамгайлж байгаа бөгөөд алс хэтдээ хоёр дахь хандлага хүчтэй болохыг үгүйсгэх аргагүй юм (Жишээ нь, Монголын тусгаар тогтнолын намын үйл ажиллагаа). Миний бодоход манайд либерал, меркантилист хоёр онолын зохистой тэнцвэрийг олж үндэсний эдийн засгаа хөгжүүлэх, аюулгүй байдлаа бэхжүүлэх асуудлыг дэлхий нийтийн аж ахуйн чиг хандлагаас салгахгүй, харин ч нягт уялдуулан явуулах нь зүйтэй мэт. Энд нэг анхаарах ёстой зүйл бол эдийн засгийн аливаа интеграцуюны өмнө газарзүйн байрлал дагаж хөгждөгийг бодолцох ёстой. Эндээс үзэхэд Монгол, Орос, Хятадын эдийн засаг алс хэтдээ интеграцчилагдах нь ээ гэсэн дүгнэлт гарч байна. Ийм интеграц хөрш орнууд гэдэг утгаар ямар нэг хэмжээгээр байх ёстой гэдэг нь тодорхой. Гэвч орчин үеийн хамгийн тэргүүний технологийг бид аж үйлдвэр өндөр хөгжсөн орнууд юм уу үгүйдээ л Азийн шинээр үйлдвэржсэн орнууд, ЗӨА-аас эрэх хэрэгтэй. Америк, Япон, Герман зэрэг өндөр хөгжсөн орнууд бид Нээс хол оршдог нь үнэн боловч тэдний технологи, хөрөнгө манайд онц чухал. Тэдний технологийн чанар хөрш орнуудынхаас хэд дахин давуу. Өрнөдийн орнуудын технологи, хөрөнгө оруулалт Монголд орох нь үндэсний аюулгүй байдлын материаллаг баталгаа болох ёстой.

«Хүйтэн дайн»-ы үеийн хоёр туйлт хатуу системийн үед өрнөсөн үзэл суртлын ширүүн тэмцэл бие даасан улсуудын дотоодын болон тэдгээрийн хоорондын шашин, соёл, үндэсний ялгаа, түүний зөрчлийг ямар нэг хэмжээгээр хязгаарлаж байлаа. Хоёр туйл алга болсноор соёл иргэншлийн хүчин зүйл улс орнуудын аюулгүй байдлын нэг чухал бүрэлдэхүүн элемент болон гарч ирэв. Соёл иргэншлийн зөрчил ялангуяа Азид, түүний дотор Монгол улсын хаяа дэрлэдэг ЗХА, Төв Азид хүчтэй өрнөх төлөв байна. Төв Азийн Бүгд Найрамдах Улсууд тусгаар тогтнолоо зарласнаар Монгол улс хэрэг дээрээ гурван томоохон соёл иргэншилтэй (Орос, Хятад, лалын) зэрэгцэн орших болж байна.

Монголын үндэсний аюулгүй байдлын дээр дурдсан шинэ хүчин зүйлүүдийн утга учир, Монголд үзүүлэх сайн, муу нөлөө, чиглэл ханд-

лагыг сайтар мэдэрч байх нь онц чухал. Гэвч тэдгээр нь аюулгүй байдлын бодлогод нөлөөлөх зөвхөн гадаад талын хүчин зүйлүүд болохоос биш дангаараа аюулгүй байдлын бодлого бус, Үндэсний аюулгүй байдлын бодлого гэдэг бол чухамдаа дээрх таван чиглэлийг зангидагч ухаалаг, уян хатан дипломат үйл ажиллагаа юм. Энэ утгаараа дипломат үйл ажиллагаа бол аюулгүй байдлын бодлогын төвлөрсөн илэрхийлэл мөн. Эндээс үзвэл таван төрлийн, дипломат үйл ажиллагаа, тухайлбал, ардчиллын, олон сурвалжит, олон улсын эрхийн, эдийн засаг, технологийн, соёл иргэншлийн дипломат үйл ажиллагаа хэрэгтэй болж байна. Эдгээр таван төрлийн дипломатыг бие биеэс нь салгах аргагүй. Тэднийг хооронд нь нягт уялдуулан, цогцолбороор явуулах ёстой. Монголын дипломатын энэхүү цогцолбор шинж хэдийчинээ сайн хангагдана, Монгол улсын аюулгүй байдал төдийчинээ бэхжинэ.

## **БЭЭЖИН-ТАЙБЭЙ. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА**

**С. Энхбаяр\***

«Тайваны асуудал» хэмээх нэр томъёо үүссээр дөч гаруй жилийн нүүр үзэж байгаа бөгөөд энэ асуудал хэрхэн бий болсныг шууд хэлэхийн урьд тайван арлын үүх түүхээс цухас дурдах хэрэгтэй юм.

Тайван арал нь эртнээс янз бүрийн улс гүрний анхаарлыг татсаар иржээ. Европчуудаас анх түрүүн португальчууд XVII зууны сүүлээр уг арал дээр очиж, үзэсгэлэн сайхныг нь бахдан «Ilina Formosa» буюу «Гайхамшгийн сайхан орон» гэдэг нэр өгсөн юм. Үүнээс хойш Тайван арал нь испани, голландчуудын эзэмшилд ээлжэн орсон ба 1661 онд Хятадын Фузянь мужийн бүрэлдэхүүнд багтан, улмаар 1886 онд Циний эзэнт улсын тусгаар мужийн статустай болжээ. Гэвч Хятад-Японы дайны дараа Симоносекийн гэрээгээр (1895. IV. 17) тус арал япончуудын мэдэлд шилжжээ. Тухайн үед Тайван арлын захирагчаар томилогдсон Гото Симпэй гэгч арлын эдийн засаг, улс төрийн ач холбогдлыг тодорхойлж: «Хэрэв Японы Засгийн газар арлыг колоничлох ажлыг гүйцэтгэж чадвал арал манай цаашдын агуу их төлөвлөгөөг хэрэгжүүлэх бааз болно. Эндээс Филиппин холгүй ба өмнөд тэнгисийн арлуудыг дамжин Гонконг, Аннам, Сингапурт, хүрэхэд дөхөмтэй. Энэ бүгд Японы эзэнт улсын захиргаанд орох ёстой. Гэхдээ энэ нь ирээдүйн хэрэг бөгөөд Тайван нь түүний баталгаа болно<sup>1</sup> гэж хэлж байжээ. Дэлхийн II дайны ид дундуур Кайрт АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт, Их Британийн ерөнхий сайд У.Черчилль, Гоминьданы засгийн тэргүүлэгч Чан Кайши нар уулзаж (1943. XI. 22—26), хамтарсан тунхаглал гаргасан бөгөөд Тайваны талаарх Хятадын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрчээ. Хожим 1945 онд 3 их гүрний Потсдамын бага хурал энэ шийдвэрийг бататгасан бөгөөд Япон үг дуугүй бууж өгсний дараа Тайван арал дахин Хятадын мэдэлд шилжсэн юм. НҮБ 1949 оны 12-р сарын 8-нд гаргасан тогтоолдоо Тайван Хятадад маргаангүй хамаарагдахыг хүлээн зөвшөөрчээ.

Хятадыг чөлөөлөгдсөний дараа Хятадын улс төрийн хоёр том хүчин-Гоминьдан болон ХКН-ын хоорондын зөрчил улам хурцадсаар иргэний дайнд хүрсэн бөгөөд уг дайнд ялагдсан гоминьданы талынхан 1949 онд Тайван арал дээр зугтан гарснаар «Тайваны асуудал» гэгч

\* МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийн хятад судлалын 1 ангийн оюутан,